

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС


ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМАНД

Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 9 дүгээр сарын 13-ны өдрийн хуралдааны 39 дүгээр тэмдэглэлд:

“ХХҮИ.ХЭЛЭЛЦСЭН нь: Зээлийн ерөнхий хэлэлцээрийн хугацааг сунгах тухай

ШИЙДВЭРЛЭСЭН нь: 1. БНХАУ-ын Засгийн газраас Монгол Улсын Засгийн газарт олгох 500 сая ам.долларын Экспортын зээлийг ашиглах тухай Монгол Улсын Сангийн яам, Хятадын Экспорт-Импорт банкны хоорондын Ерөнхий хэлэлцээрийн хүчинтэй хугацааг сунгах тухай асуудлыг хэлэлцээд зарчмын хувьд дэмжив.

2. Зээлийн ерөнхий хэлэлцээрийн хүчинтэй хугацааг сунгаж байгаатай холбогдуулан уг зээлийн хүрээнд хэрэгжүүлэх “Улиастай-Тосонцэнгэл чиглэлийн Загастайн давааны 67 км хатуу хучилттай авто зам барих” төслийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шуурхай зохион байгуулахыг Зам, тээврийн хөгжлийн сайдын үүрэг гүйцэтгэгч Д.Ганбатад даалгав.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР